



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ


184 /184/ 2021.11.19

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

ТУСГАЙ ДУГААР

ЦЭРГИЙН АР ТАЛЫН ТЭНХИМ 40 ЖИЛ

МЭНДЧИЛТЭЭ



Цэргийн ар талын мэргэжлийн боловсон хүчнийг эх орондоо бэлтгэх шийдвэрийг БХЯ-ны сайдын 1981 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 242 дугаар тушаалаар баталгаажуулснаар Цэргийн ар талын тэнхимийн үүсэл, хөгжил эхэлсэн түүхтэй. Энэ хугацаанд 1981-1992 онд ЦНДС-ийн Ар талын кафедр, 1992-2001 онд

ЕЗЦС-ийн Ар тал, эдийн засгийн тэнхим, 2001-2010 онд ЦКИС-ийн Цэргийн ар талын тэнхим, 2010-2015 онд ЦКС-ийн Цэргийн ар тал, эдийн засгийн тэнхим, 2015-2017 онд ЦНДС-ийн Цэргийн хангалт тээврийн тэнхим, 2017 оноос ЦНДС-ийн Цэргийн ар талын тэнхим нэртэйгээр сургалтын үйл ажиллагаа явуулж ирсэн түүхтэй.

Цэргийн ар талын тэнхим энэхүү түүхэн цаг хугацаанд 32 удаагийн төгсөлтөөр цэргийн ар талын мэргэжлийн 800 гаруй офицерыг Зэвсэгт хүчний хэрэгцээ, шаардлага, шалгуурт нийцүүлэн бэлтгэжээ. Тус тэнхимийн төгсөгчдөөс Н.Наранбаатар, С.Бямбацогт нарын төрийн түшээд, хошууч генерал Г.Ариунбуян, бригадын генерал М.Эрдэнэдалай, Б.Ганбаатар, Б.Ууганбаяр, Д.Ганхуяг нарын генералууд, Монгол Улсын Гавьяат барилгачин Ц.Зулхүү, Цэргийн шинжлэх ухааны доктор (Ph.D), хурандаа Л.Баатар, Аюулгүй байдлын доктор (Ph.D), дэд хурандаа Т.Мөнх-Оргил нарын эрдэмтэн, докторууд төрөн гарсан нь бидний бахархал билээ. Түүнчлэн БХЯ, ЗХЖШ-ын газар, хэлтсийн дарга нар Зэвсэгт хүчний материал хангалтын бодлогыг тодорхойлж, ар талын ангийн захирагч нар цэргийн мэргэжлийн болон захиргааны удирдлагаар ханган, бригад, тусгай хорооны ар талын дарга,

ангиудын ар талын албадын дарга нар гардан хэрэгжүүлж байгаа нь тус тэнхимийн төгсөгчдийн мэргэжлийн ур чадварыг харуулж байгаа юм. Цэргийн ар талын тэнхим нь Цэргийн ар талын командын мэргэжлээр бакалаврын, "Цэргийн материал, техникийн хангалт" хөтөлбөрөөр магистрын сургалт явуулж, олон улсын боловсролын стандарт, магадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөрөөр сургах сургалт, судалгааны тэнхим болох зорилготой үйл ажиллагаагаа явуулж байгааг ойн энэ өдөр онлон тэмдэглэхэд таатай байна. Тэнхимийг үүсгэн байгуулах, өргөжүүлэн бэхжүүлэхэд залуу нас, оюун ухаан, эрдэм мэдлэг, хичээл зүтгэлээ харамгүй зориулсан ахмад багш, ажилчид болон тэнхимийн үе үеийн төгсөгчдөөдө Цэргийн ар талын тэнхимийн 40 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлье.

Монгол цэргийн цог хийморь үеийн үед мандан бадрах болтугай.
ЦЭРГИЙН АР ТАЛЫН ТЭНХИМИЙН ДАРГА, ХУРАНДАА ХАЛТАРЫН ЭРДЭНЭЧИМЭГ

ТЭНХИМИЙН ЗОРИЛГО

Цэргийн ар талын тэнхим нь "Цэргийн ар талын команд" бакалаврын хөтөлбөрийн дагуу сургалтын үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн тэнхим юм. "Цэргийн ар талын команд" сургалтын хөтөлбөрийн зорилго: "Материал хэрэгслийн хангалтын өргөн мэдлэг, ур чадвартай, ёс зүйн зөв төлөвшилтэй, захиалагч байгууллагын эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн цэргийн ар талын командын офицер бэлтгэхэд оршино"



ТЭНХИМЭЭС ТӨРСӨН АЛДАРТНУУД:

- Н.Наранбаатар /1996 оны төгсөгч/-Улсын их хурлын гишүүн
- С.Бямбацогт /1996 оны төгсөгч/ - Улсын их хурлын гишүүн
- Дэслэгч генерал Д.Даваа /2000-2006 онд тэнхимийн дарга/ – Монгол Улсаас ОХУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд
- Бригадын генерал Д.Ганхуяг /1996 оны төгсөгч/ – Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга
- Хошууч генерал Г.Ариунбуян /1996 оны төгсөгч/ – Онцгой байдлын Ерөнхий газрын дарга
- Ц.Зулхүү /1993 оны төгсөгч/ - Гавьяат барилгачин
- Бригадын генерал М.Эрдэнэдалай /1985 оны төгсөгч/- Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн зөвлөх
- Бригадын генерал Б.Ганбаатар /1990 оны төгсөгч/- "Багабаян энхийн төлөө цогцолбор төв" ТӨААТҮГ-ын захирал
- Бригадын генерал Б.Ууганбаяр /1991 оны төгсөгч/- Онцгой байдлын Ерөнхий газрын орлогч дарга

ЭНЭ ХУГАЦААНД ТЭНХИМИЙН ДАРГААР:



- 1981-1992 онд хурандаа А.Баттулга
- 1992-1996 онд хурандаа Ж.Наман
- 1997-1999 онд ахмад С.Бямбасүрэн
- 1999-2002 онд хурандаа А.Баттулга
- 2002-2008 онд дэслэгч генерал Д.Даваа
- 2008-2010 онд хурандаа Б.Галсандаш
- 2010-2011 онд дэд хурандаа С.Бямбасүрэн
- 2011-2015 онд дэд хурандаа Л.Төмөрбаатар
- 2015-2017 онд хурандаа Г.Идэр
- 2017-2020 онд хурандаа Л.Төмөрбаатар
- 2020 оны 10 дугаар сараас хурандаа Х.Эрдэнэчимэг ажиллаж байна.

ТЭНХИМЭЭС ТӨРСӨН АЛДАРТНУУД

- Н.Наранбаатар /1996 оны төгсөгч/ - Улсын их хурлын гишүүн
- С.Бямбацогт /1996 оны төгсөгч/ - Улсын их хурлын гишүүн
- Дэслэгч генерал Д.Даваа /2000-2006 онд тэнхимийн дарга/ – Монгол Улсаас ОХУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд
- Бригадын генерал Д.Ганхуяг /1996 оны төгсөгч/ – Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга
- Хошууч генерал Г.Ариунбуян /1996 оны төгсөгч/ –

- Онцгой байдлын Ерөнхий газрын дарга
- Ц.Зулхүү /1993 оны төгсөгч/ - Гавьяат барилгачин
- Бригадын генерал М.Эрдэнэдалай /1985 оны төгсөгч/ - Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн зөвлөх
- Бригадын генерал Б.Ганбаатар /1990 оны төгсөгч/ - "Багабаян энхийн төлөө цогцолбор төв" ТӨААТҮГ-ын захирал
- Бригадын генерал Б.Ууганбаяр /1991 оны төгсөгч/ - Онцгой байдлын Ерөнхий газрын орлогч дарга

ТЭНХИМЭЭС ТӨРСӨН ЭРДЭМТЭД

- Хурандаа Ж.Энхбаяр 2015 онд,
- Багш Д.Энхчимэг 2015 онд,
- Дэд хурандаа Т.Мөнх-Оргил 2019 онд,
- Хурандаа Л.Баатар 2020 онд тус тус докторын зэрэг хамгаалсан байна.

Тэнхимийн төгсөгч Д.Одгэрэл анх хурандаа цол авснаас хойш одоогийн байдлаар зургаан генерал, 38 хурандаа цолтой офицер төрөн гарсан бөгөөд тэдгээрийн зарим нь БХЯ, ЗХЖШ, ОБЕГ-ын дарга, орлогч, ТНБД, газар, хэлтэл, командлалын дарга, ангийн захирагч болж удирдан чиглүүлж, Зэвсэгт хүчний материал хангалтын бодлогыг тодорхойлж байгаа нь манай тэнхимийн төгсөгчдийн мэргэжлийн ур чадварыг харуулж байгаа нэг томоохон илэрхийлэл болж байна. Мөн бригад, тусгай хорооны ар талын дарга, захирагчийн орлогч, ангиудын ар талын албадын дарга нарын ихэнх нь тус тэнхимийн төгсөгчид байдаг.

Цаг хугацааны явцад янз бүрийн өөрчлөлт шинэчлэлд өртөж байсны нэг илрэл нь 2010 онд Цэргийн ар талын тэнхимийг Удирдлага, технологийн сургуулийн Эдийн засгийн тэнхимтэй нэгтгэж, Цэргийн командын сургуулийн бүрэлдэхүүнд оруулан «Цэргийн ар тал, эдийн засгийн тэнхим» гэж нэрлэж байсан бол БХЯ-ны ТНБД-ын 2015 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн н/03 дугаар тушаалаар ЦНДС-ийн Цэргийн хангалт, тээврийн тэнхимтэй нийлүүлж, 2017 оны 9 дүгээр сараас эхлэн дангаараа Цэргийн ар талын тэнхим нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

МАНАЙ ТӨГСӨГЧИД

Тус тэнхим энэ хугацаанд ар талын дээд мэргэжлээр 900 гаруй офицер, өдөр, эчнээ ангийн 1000 орчим оюутан төгссөсөн бөгөөд 2013 онд ар талын тоног төхөөрөмжийн дамжаа, 2014, 2019, 2021 онд эд хариуцагчийн дамжаа, 2015, 2019, 2021 онд ар талын мэргэжлийн офицеруудын мэргэжил дээшлүүлэх дамжааг хичээллүүлж төгссөн. Мөн ар талын мэргэжлийн 90 гаруй бэлтгэл офицерыг дараах мэргэжлүүдээр бэлтгэж гаргасан:

- 2012 онд хүнсний мэргэжлээр 10
- 2013 онд хүнсний мэргэжлээр 10
- 2014 онд цэргийн ар тал хүнсний технологич мэргэжлээр 10
- 2015 онд дотрын эмч мэргэжлээр 10
- 2016 онд хувцасны мэргэжлээр 7, Халдвартын эмч мэргэжлээр 11
- 2017 онд хувцасны мэргэжлээр 5, хүнсний мэргэжлээр 5
- 2019 онд хүнсний технологич, Ар талын бэлтгэл офицер-23



ТЭНХИМЭЭС ТӨРСӨН ЭРДЭМТЭД:

- Хурандаа Ж.Энхбаяр 2015 онд,
- Багш Д.Энхчимэг 2015 онд,
- Дэд хурандаа Т.Мөнх-Оргил 2019 онд,
- Хурандаа Л.Баатар 2020 онд тус тус докторын зэрэг хамгаалсан байна.



ТҮҮХЭН ЗАМНАЛ

1921 оны 3 дугаар сарын 13-нд байгуулагдсан Ардын Түр Засгийн Газар нь анхны үеэсээ эхлэн ардын

гэр майхныг журамт цэрэгт элсэгчдийн хувийн, ард олноос сайн дураар туслан нийлүүлсэн эд хэрэглэл

үүссэн юм. Учир нь ЗХУ-д цэргийн дээд, дунд сургуульд цөөн тооны хүмүүсийг сургаж байсан төдийгүй, ар талын мэргэжлийн дээд боловсролтой офицер ихээхэн дутагдаж, цэргийн олон ангиудын ар талын албанд мэргэжлийн бус, нас сүүдэр нэлээд хэвийсэн офицеруудыг томилон ажиллуулахад хүрсэн нь тухайн үед тавигдаж байсан шаардлагыг илт хангахгүй зэрэг асуудлууд гарсан тул дэслэгч генерал Ц.Дашзэвэг Монгол Ардын Армийн Ар талын штабын орлогч даргын албан тушаалыг хашиж байх үедээ ар талын боловсон хүчнийг дотооддоо бэлтгэх

бэлтгэх тэнхимийг байгуулснаар төсөгчид нь бригад, тусгай хорооны албаны даргаар бэлтгэгдэж, цэрэгжилт, жагсаалч байдал, цэргийн дүрэмт хувцсыг өмсөж хэрэглэх зэрэг цэргийн албаны асуудлаар бусад төсөгчдөөс онцгой ялгарч Зэвсэгт хүчний түүхэнд нэгэн шинэ хуудсыг нээсэн нь тус тэнхимийн эрдэмтэн багш нар, рот, курсийн даргаар ажиллаж байсан албан тушаалтнуудын шаргуу хөдөлмөрийн үр дүн юм. Төгсөгчдийн дурсамжаас эргэн сөхвөл эхэн үеийн төсөгчдөд өндөр хариуцлага ноогддог байжээ. Тухайлбал, улс орны эдийн засаг төлөвлөгөөт эдийн



цэргийн гурван гол зорилтын нэг "Улаан цэргийн алив хэрэглэгдэхүүнийг засацгаан бэлтгэж, ардын дайсныг дарах хэрэгт дутагдал гачигдалгүй болгохыг хичээж элдэв зэр зэвсэг, хувцас хунар, хоол хүнс зэрэг чухлыг бэлтгэх явдлыг сайжруулах шаардлагатай" хэмээн үзэж уг зорилтоо хэрэгжүүлж эхэлснээр Зэвсэгт хүчний ар талын байгууллагын түүх эхэлдэг.

хийгээд хошуудаас албан оногдлоор гаргуулах, заримыг худалдан авах зэргээр хангаж байжээ.

Ардын цэргийн Ар талын байгууллага жилээс жилд өргөтгөн зохион байгуулагдаж нэгтгэл, ангиудын үйл ажиллагаа, сургалт бэлтгэл явуулах хэвийн нөхцөлийг бүрдүүлэх, дайчдын эрүүл мэндийг хамгаалах, хоол хүнс, хувцас, орон сууц болон нэгтгэл, анги, салбаруудыг байлдаанд бэлэн байх



санал боловсруулж, БХЯ-ны орлогч сайд, МАА-ийн Ар талыг удирдах газрын дарга, хошууч генерал Я.Дамдинжав нараар дэмжүүлэн, уг саналаа БХЯ-ны Боловсон хүчний газраар дамжуулан, БХЯ-ны коллиги, Улс төрийн товчоонд оруулсан юм.

Уг санал дэмжигдэн 1981 онд БХЯ-ны сайдын 242 дугаар тушаал гарч, ЦНДС-д Цэргийн

засгаас зах зээлийн эдийн засагт шилжих хямралын хүнд хэцүү үе тохиосон ч Зэвсэгт хүчний ар талын хангалт, үйл ажиллагааг ямар нэгэн доголдолгүй давж, цэргийн шинэчлэлийн бодлогыг анги, салбарт амжилттай хэрэгжүүлэн ар талын байгууллагын нэр хүндийг өндөрт өргөж явсан нь багш, төсөгчдийн түүхэн гавьяа зүтгэлээс улбаатай билээ.



Ардын Түр Засгийн газрын хуралдаан болж Цэргийн яамны зохион байгуулалт хийхдээ яаманд "Бэлтгэлийн хэлтэс" байгуулсан нь ар талын байгууллагын үүсэл юм. Тус хэлтэс нь цэргийн хэрэглэл зэргийг бэлтгэн нийлүүлэх ба зохих газруудад түгээн олгох чухал ажлыг нугалж байв. Хөрөнгө чинээний боломжоос шалтгаалан цэргийг төвлөрсөн журмаар хангах ямар ч бололцоогүй энэ нөхцөлд зэр зэвсгийн хангалтыг ЗХУ-аас үзүүлсэн тусламжийн буу зэвсгийг хуваарилан Хувийн, Олзны зэвсэг хэрэглэх замаар хангаж, харин цэргийн хүнс хэрэглэл, уналга морьд,

нөхцөлөөр хангах, шатахуун, галт хэрэгсэл, материал техник хэрэгслийн нөөц бүрдүүлэх зэрэг тулгамдсан олон асуудлыг амжилттай шийдвэрлэж, өөрийн зохион байгуулалтын хувьд бэхжиж, бэлэн байдал, үүрэг гүйцэтгэх чадвараа нэмэгдүүлсээр иржээ.

1970-аад оны сүүлч, 1980 оны эхэн бол Монгол Улсын Батлан хамгаалах салбарын хүч чадлыг бэхжүүлэхэд чиглэсэн өргөн хүрээтэй арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн он жилүүд байв. Гэсэн хэдий ч цэргийн ар талын мэргэжлээр офицерыг нөхөн хангахад ихээхэн бэрхшээл



ар талын ангийг шинээр нээж, 1981-1982 оны хичээлийн жилд цэргийн хүнс, хувцасны мэргэжлээр элсэлт авч, улмаар дараагийн жилүүдэд шатахуун, санхүү, орон сууцны хангалтын мэргэжилтэй офицер, боловсон хүчнийг бэлтгэж эхэлсэн байна.

Кафедр болоход анхны тэнхимийн даргаар ахмад А.Баттулга, ротын захирагчаар ахлах дэслэгч Б.Маяахүү, улс төрийн орлогчоор ахлах дэслэгч Г.Түдэвдорж, курсийн даргаар ахлах дэслэгч Д.Цогт-Эрдэнэ, Ч.Баярсайхан нар томилогдон тус тэнхимийн тулганы галыг асаажээ.

Ийнхүү ар талын дээд боловсролтой мэргэжилтнийг

Цэргийн ар талын тэнхим нь түүхийн 40 жилийн хугацаанд дараах байдлаар өөрчлөн зохион байгуулагдсан юм.

- 1981-1992 онд ЦНДС-ийн Ар талын кафедр
- 1992-2001 онд ЕЗЦС-ийн Ар тал, эдийн засгийн тэнхим
- 2001-2010 онд ЦКИС-ийн Цэргийн ар талын тэнхим
- 2010-2015 онд ЦКС-ийн Цэргийн ар тал, эдийн засгийн тэнхим
- 2015-2017 онд ЦНДС-ийн Цэргийн хангалт тээврийн тэнхим
- 2017 оноос ЦНДС-ийн Цэргийн ар талын тэнхим нэртэйгээр сургалтын үйл ажиллагаа явуулж байна.



ТЭНХИМИЙН АМЖИЛТУУД:

- 2011 онд БХИС-ийн "Тэргүүний тохижилттой тэнхим"
- 2012 онд БХИС-ийн "Тэргүүний эрдэм шинжилгээний төв"
- 2013 онд БХИС-ийн "Тэргүүний эрдэм шинжилгээний төв"-ийн дэд байрын шагнал
- 2013 онд БХИС-ийн оюутан сурагчдын урлагийн үзлэгийн дэд болон гутгаар байр
- 2014 онд ЦКС-ийн "Эрдэм шинжилгээний тэргүүний тэнхим"
- 2015 онд ЦАТЭЗТ-ийн багш Ш.Гантуяа БХИС-ийн "Тэргүүний заах арга зүйч багш", С.Туул "Оны тэргүүний багш"
- 2016 онд ахлах дэслэгч Д.Мөнхбат БХИС-ийн "Тэргүүний залуу багш"
- 2015 оны 3 дугаар сарын 27-ны өдөр "Монгол Улсын макро эдийн засгийн тулгамдаж буй асуудлууд" сэдэвт багш нарын эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулагдаж 10 илтгэл хэлэлцэгдэж дараах илтгэлүүд шалгарав. Үүнд: "Батлан хамгаалахын төсөвт хийсэн шинжилгээ, тулгамдаж буй асуудал" сэдвээр багш, ахлах дэслэгч Д.Мөнхбат I байрт, "Хөрөнгийн зах зээл болон макро эдийн засгийн хамаарлын судалгаа" сэдвээр багш С.Туул I байрт, "Далд эдийн засагт татварын үзүүлэх нөлөө" сэдвээр багш Б.Юмаажав III байрт тус тус шалгарсан юм.
- Багш, ахлах дэслэгч Д.Мөнхбат "БХИС-ийн эрдмийн чуулган"-ны нийгмийн ухааны салбар хуралдаанд мөн II байр эзэлсэн.
- 2015 оны 2 дугаар сард БХИС-иас зохион байгуулсан "Багшлах эрдэм ухаан-арга зүй" сэдэвт эрдэм шинжилгээний хуралд багш Ш.Гантуяа "Багшийн сургах арга зүй /Идэвхтэй сургалтын арга/" сэдэвт илтгэлээр амжилттай оролцож II байр эзэлсэн.
- Үндэсний тагнуулын академиас 2015 оны 3 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан "Эдийн засгийн нөхцөл байдал ба гүйцэтгэх ажил" сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын "Батлан хамгаалах төсөвт хийсэн шинжилгээ, тулгамдаж буй асуудал" салбар хуралдаанд багш, ахлах дэслэгч Д.Мөнхбат "Батлан хамгаалахын төсөвт хийсэн шинжилгээ, тулгамдаж буй асуудал" сэдэвт илтгэлээр амжилттай оролцож дэд байрт шалгарсан.
- Тэнхимийн IV курсийн сонсогч Д.Төрболд Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны тэтгэлэг хүртэж, сонсогч А.Ариунаа ҮБХИС-ийн "Тэргүүний тамирчин"-аар шалгарсан.
- 2020 онд ахлах дэслэгч Б.Цэрэнчимэд ЦНДС-ийн "Шилдэг инновацын бүтээл"-ийн тэргүүн байр
- 2021 онд ахлах дэслэгч Б.Цэрэнчимэд ҮБХИС-ийн ЭШХ-ийн "Шилдэг удирдагч"-ийн дэд байр
- 2021 онд ХСИС-ийн ХАС-н АТЭЗТ-ийн ЭШХ-д оролцож ахлах дэслэгч М.Мөнгөнцэцэг II, Б.Цэрэнчимэд III байрт шалгарсан.



ЦААШИД ЯВАГДАХ СУРГАЛТУУД:



- Магистрын сургалт "Цэргийн материал техникийн хангалт"
- Бакалаврын өдрийн болон эчнээ сургалт "Цэргийн ар талын команд"
- Ар талын офицерын мэргэжил дээшлүүлэх дамжаа
- Бэлтгэл офицерын дамжаа
- Эд хариуцагчийн дамжаа
- Тоног төхөөрөмжийн засварчны дамжаа